



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ҮНДЭСНИЙ СУДАЛГАА
ЗӨВЛӨГӨӨНИЙ ТӨВ

ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨРИЙГ ДЭМЖИЦГЭЭЕ!

Албадан хөдөлмөр гэж юу вэ?

Тухайн хүн өөрөө хүсээгүй эсхүл аливаа шийтгэл ногдуулахаар сүрдүүлж ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхийг хэлнэ.

“ДЭЛХИЙ НИЙТЭЭРЭЭ АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХЫГ ЗОРЬЖ БАЙНА.”

Тогтвортой хөгжлийн 8 дахь зорилт буюу Зохистой хөдөлмөр, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилтын нэг хүрэх үр дүн нь 2030 он гэхэд албадан хөдөлмөрийг дэлхий нийтээр устгахыг зорьж байна.

АЛБАДАН ХӨДӨЛМӨР БАЙЖ БОЛЗОШГУЙ ШИНЖ ТЭМДЭГ

Шинж тэмдэг		Тайлбар
	Эмзэг байдлыг нь далимдуулах	Тухайн орны хэл, хуулийг мэдэхгүй, амьжиргаагаа залгуулах боломж хязгаарлагдмал, шашны болон угсаатны цөөнхөд хамаардаг, хөгжлийн бэрхшээл буюу бусад байдлаараа хүн амын олонхоос ялгардаг хүмүүс албадан хөдөлмөрт өртөх эрсдэл өндөр юм. Мөн ажил олгогчоосоо орон байр, хоол хүнс, хамаатан садны ажлын байр зэрэг зүйлээр хараат байгаагаас болж албадан хөдөлмөрт өртөх магадлал ихэснэ.
	Хууран мэхлэх	Амаар болон бичгээр өгсөн амлалтаа биелүүлэхгүй байхыг ойлгоно. Цалин хөлс сайтай, сайн ажилд оруулна гэсэн амлалтад хууртаж ажилд орсон бол бодит мэдээлэлд тулгуурлан сайн дураараа зөвшөөрсөн гэж үзэхгүй. Амлалт нь хийх ажлын төрөл, орон байр, амьдрах нөхцөл, байнгын оршин суугч болох боломж зэрэг юу ч байх боломжтой.
	Чөлөөтэй зорчихыг хязгаарлах	Зугтахгаас сэргийлэн ажлын байр болон зөөж тээвэрлэх явцдаа цоохиж, харуул хамгаалалттай байлгахын зэрэгцээ тодорхой хязгаарлалтаас гадуур ажлын байрандаа чөлөөтэй орж, гарах боломжгүй байхыг ойлгоно. Гэхдээ аюултай ажлын байрны аюулгүй байдлыг хангах зорилгоор хязгаарлалт тогтоох, эсхүл ажлын цагаар хувийн зорилгоор гарах бол удирдлагаасаа урьдчилан чөлөө авах шаардлага нь чөлөөтэй зорчихыг хязгаарлаж буй хэрэг биш юм.
	Тусгаарлах	Албадан хөдөлмөрийн хохирогч нь ихэвчлэн гадаад ертөнцтэй холбогдох боломжгүй, алслагдсан газарт байдаг. Алслагдсан газар биш байлаа ч цоожтой хаалганы цаана байлгах, гар утас, харилцаа холбооны бусад хэрэгслийг хураан авах замаар тусгаарлах боломжтой. Ялангуяа албан ёсны бүртгэлгүй ажлын байранд ажилтнуудыг ийнхүү тусгаарлах эрсдэлтэй.
	Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлэх	Албадан хөдөлмөрт өртөгсөд болон тэдний гэр бүлийн гишүүн, ойр тойрны хүмүүс нь бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж болзошгүй. Мөн мансууруулах бодис, согтууруулах ундаа хүчээр хэрэглүүлэх нь ч бий. Ажилтанд хүч хэрэглэж анх тохирсноосоо өөр ажил хийлгэх, эсхүл бэлгийн харьцаанд орохыг шаардах, нэмэлтээр гэр орны ажил хийлгэхийг тулгах зэрэг ч мөн үүнд багтана.

	Айлган сүрдүүлэх, заналхийлэх	Албадан хөдөлмөрийн хохирогчид нөхцөл байдлын талаар гомдол гаргах, эсхүл ажлаасаа гарах хүслээ илэрхийлсний төлөө сүрдүүлэг, заналхийлэлд өртөх эрсдэлтэй. Бие махбодын хүчирхийллээс гадна цагаачлалын албанд мэдэгдэх, цалин хөлс, газраа алдах, гэр бүлийн гишүүдийг ажлаас халах, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг дордуулах зэргээр сүрдүүлдэг. Мөн байнга гутаан доромжлох, дорд үзэх явдал ч үүнд хамаарна.
	Бичиг баримтыг нь барьцаалах	Ажилтны бичиг баримт, хувийн үнэт зүйлсийг ажил олгогч барьцаалсны улмаас шаардлагатай үедээ явж чадахгүй, тэдгээрийг орхиод ажлаасаа гарч чадахгүй байхыг ойлгоно.
	Цалингаар нь барьцаалах	Ажилтнууд авах ёстой цалин хөлсөө хүлээгээд ажил олгогчийн зүй бус авиртай эвлэрэхээс өөр аргагүй байхыг ойлгоно. Гэхдээ тухайн ажилтныг үлдээх арга хэрэгсэл болгож, зохион байгуулалттайгаар зориуд цалин хөлс олгохгүй барьцаалж, ажил олгогчоо солих боломжгүй болгож байвал албадан хөдөлмөр болно.
	Өрийн барьцаа, төлөөс болгох	Албадан хөдөлмөрт өртөгсөд ихэвчлэн өөрийнхөө тавьсан, заримдаа өөр бусдаас өвлөн авсан өрийг дарах гэж ажилладаг. Энэ өр шир нь урьдчилгаа болгож авсан цалин хөлс, ажилд орох зуучлалын хөлс, тээврийн зардлаа төлөх гэж авсан зээл, өөр бусад амьжиргаатай холбоотой зардлаас үүсэж болно. Зарим тохиолдолд бичиг үсэггүй байдлыг далимдуулан өрийг улам нэмэгдүүлэх ч тохиолдол байна. Мөн эцэг эх, хамаатан саданд олгосон зээлийн оронд хүүхдийг нь авч ажиллуулах ч хамаарна. Ажил олгогч ажилтны ажлыг доогуур үнэлэх, зээлийн хүүг зохиомлоор өсгөх, хоол хүнс, орон байраар хангасны төлөө төлбөр нэхэх зэргээр өрнөөс салах аргагүй болгох тохиолдол ч мөн үүнд хамаарна.
	Тэвчишгүй нөхцөлд ажиллуулж, амьдруулах	Сайн дураараа хэзээ ч зөвшөөрөхгүй ажил, амьдралын хүнд нөхцөлийг тэвчихэд хүрч байвал үүнд хамаарна. Гутаан доромжилсон, бохир заваан нөхцөлд эхцүү, зохих хамгаалалтгүй аюултай, хөдөлмөрийн хууль ноцтой зөрчсөн нөхцөлд ажиллуулахыг ойлгоно. Мөн хувийн орон зайгүй, хэт олуулаа, шахцалдсан, эрүүл бус буюу хэвийн бус нөхцөлд амьдруулах ч үүнд хамаарна. Гэхдээ ажиллах, амьдрах нөхцөл маш муу байх нь дангаараа албадан хөдөлмөрийн нотолгоо болохгүй.
	Хэт уртасгасан цагаар ажиллуулах	Хууль, хамтын гэрээгээр тогтоосон хязгаараас илүү урт буюу хэт олон цаг, хоногоор ажиллуулахыг ойлгоно. Илүү цагаар ажиллуулсан нь албадан хөдөлмөрлүүлсэн гэмт хэрэг мөн эсэхийг тогтоох нь төвөгтэй ч ажилтныг ямар нэг заналхийлэл дор, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалин авахын тулд илүү цагийн дээд хязгаараас (7 хоногт 54 цагаас илүү) илүү олон цагаар ажиллуулж байвал энэ нь албадан хөдөлмөр болно.

Албадан хөдөлмөрт өртсөн эсэхээ дараах шинжээр шалгаж үзээрэй.

Шинж тэмдэг	Тийм	Үгүй
Эмзэг байдлыг далимдуулсан		
Хууран мэхэлсэн		
Чөлөөтэй зорчихыг хязгаарласан		
Тусгаарласан		
Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлсэн		
Айлган сүрдүүлж, заналхийлсэн		
Бичиг баримтыг барьцаалсан		
Цалингаар барьцаалсан		
Өрийн барьцаа, төлөөс болгож ажиллуулсан		
Тэвчишгүй нөхцөлд ажиллуулж, амьдруулсан		
Хэт уртасгасан цагаар ажиллуулсан		

Хэрэв та дээрх шинжүүдийн аль нэгд **“ТИЙМ”** гэж хариулсан бол дараах байгууллагад хандан гомдол, мэдээлэл гаргах боломжтой.

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Утас: 7000 - 0222;
Цахим хуудас: www.nhrcm.gov.mn;
- Цагдаагийн байгууллага, Утас: 102
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн бодлогын газар,
Утас: 261416

АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ, ХОРИГЛОХ АСУУДЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Монгол Улсын
Үндсэн хууль



Хөдөлмөрийн
тухай хууль



Эрүүгийн
хууль

Монгол Улсын Үндсэн хууль

Арван зургадугаар зүйл.

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

...

4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.

Олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө Монгол Улсын хүлээсэн үүрэг

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцод 2005 онд нэгдэн орсон.

Хөдөлмөрийн тухай хууль

..5 дугаар зүйл. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны суурь зарчим, үндсэн эрх

5.1. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд оролцогч дараах суурь зарчмыг баримталж, холбогдох үндсэн эрхийг эдэлнэ:

5.1.1. үл ялгаварлан гадуурхах;

5.1.2. хөдөлмөрлөх эрх чөлөөг баталгаажуулах, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах, цалин хөлс авах, амрах;

5.1.3. дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох;

5.1.4. албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох;

5.1.5. барьцаа хэрэглэхгүй байх;

5.1.6. эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах, ажилтан, ажил олгогч, тэдгээрийн төлөөлөгчдийн хоорондын харилцааг зохицуулах эрхийг хангах;

5.1.7. шударга бус үйлдлийг хориглох;

5.1.8. нийгмийн түншлэлийг хангах;

5.1.9. хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах

8 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох

8.1. Хэнийг ч албадан хөдөлмөрлүүлэхийг хориглоно.

8.2. "Албадан хөдөлмөрлүүлэх" гэж аливаа торгууль, шийтгэл ногдуулахаар айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг ажил, үйлчилгээ эрхлүүлэхийг ойлгоно.

8.3. Дараах ажил, үйлчилгээ албадан хөдөлмөрлүүлэхэд хамаарахгүй:

8.3.1. суурь боловсрол эзэмших;

8.3.2. хугацаат цэргийн албан хаагчийн хийж гүйцэтгэж байгаа цэргийн зориулалттай ажил, үйлчилгээ;

8.3.3. тухайн нутаг дэвсгэр, хот, тосгон, суурин газрын оршин суугчийн хувьд хийх тохижилт, цэвэрлэгээний хөнгөн ажил;

8.3.4. шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл ял эдлэх явцад төрийн байгууллага, албан хаагчийн удирдлага, хяналтын доор хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээ. Ялтныг аливаа хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллуулах, тэдний мэдэлд шилжүүлэхийг хориглоно;

8.3.5. улс орныг батлан хамгаалах, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгэх, гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг нэн даруй арилгахтай холбоотой ажил, үйлчилгээ.

8.4. Хүнийг албадан хөдөлмөрлүүлсэн, албадан хөдөлмөрлүүлэхэд зуучилсан, зохион байгуулсан хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүгийн хууль

13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх

Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

“Эн Ар Си Си” ХХК

Монгол улс
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Чингисийн өргөн чөлөө,
Business Tower 502#,

Утас: 976-77007270

☎ NRCC

✉ Contact@nrcc.mn

🌐 www.nrcc.mn